



"ЗООНОЗЫН ӨВЧИН
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ"-Д

УБЗТИ-ийн 2013 оны 05 дугаар сарын 05-ны өдөр
УБЗТИ-ийн 2013 оны 05 дугаар сарын 05-ны өдөр
УБЗТИ-ийн 2013 оны 05 дугаар сарын 05-ны өдөр
УБЗТИ-ийн 2013 оны 05 дугаар сарын 05-ны өдөр

2013-05-01 № 02-01-90/726

Барилгын ашиглалтын төлөв
байдлын тухай

Танай байгууллагаас тус газарт "Барилгын ашиглалтын төлөв байдалд дүгнэлт гаргуулах"-аар 2013 оны 03 дугаар сарын 22-ны 1/98 тоотоор ирүүлсэн хүсэлт, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дэд даргын "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдөр баталсан 02-02/16 тоот удирдамжийн дагуу Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо, Зоонозын өвчин судлалын төвийн барилгад 2013 оны 05 дугаар сарын 05-ны өдөр ажлын албаны дарга С.Болдбаатарыг байлцуулан шалгалт хийлээ.

Байгалийн голомтод халдварт өвчин судлалын мэдээлэл судалгааны зориулалтаар үйл ажиллагаа явуулдаг улсын хэмжээний лаборатори нь төв корпус, тусгаарлах байр, шинжилгээний байр, био үйлдвэрлэлийн лаборатори, автограж зэрэг барилгуудаас бүрдсэн, төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдсон, нэгээс хоёр давхар, лабораторийн барилгад 2009 онд өргөтгөл хийсэн, бусад барилгад 1979 оноос хойш дээрх зориулалтаар үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Шалгалтаар:

А.Төв корпусын барилга:

1.Энэхүү барилга нь хуучнаар УБЗТИ-д боловсруулсан зураг төслөөр тэнхлэгээрээ 67.0x16.0 метрийн хэмжээтэй, угсармал төмөр бетон суурьтай, даацын тоосгон ханатай, угсармал төмөр бетон хавтан хучилттай, хавтгай дээвэртэй, хоёр давхраар төлөвлөгдөн баригдсан ба 2007 онд барилгын дээврийн хийцийг өөрчлөн шувуун нуруу бүхий төмөр дээвэртэй болгон засварласан байна.

2. Тус байрны чанарын тасаг, хүний нөөцийн менежер, мөн харалдаах захирлын туслах, дэд захирлын өрөөний өрөө тусгаарлах хамар хана шалнаасаа

001-30503183

дээшээ 20-40 см орчим хөндлөн болон бетон шал хананаасаа тасарч эргэн тойрон суулт үүссэн;

3. Хоёрдугаар давхрын танадалт судлалын өрөөний баруун урд өнцөгөөс гурван метр орчим ташуу хэлбэртэй, цууралт үүсэж, цонхны шил хагарсан, тэр хэсгийн бетон хаяавч хагарсан, суулт өгсөн, лабораторийн албаны даргын өрөөний баруун хойт буланд ус нэвчин мөөгөнцөрт идэгдсэн, хучилтын хавтангийн заадсын чигжээс, замазка, эмүльс хуурч унасан;

4. Халаалтын болон цэвэр усны шугамаас ус их хэмжээгээр алдаж байснаас шалан доогуур явж байгаа суваг ус чийгэнд идэгдсэн, тэр хэсгийн хөрсөнд суулт үүссэн;

5. Барилгын дээврийн ус цуглуулагч хуванцар хоолой, цорго нь зарим газраараа тасарч салсан, тэр хэсгээр орсон хур тундасны ус банзан поронтон, ханыг норгон улмаар хана таазанд нэвчилт өгч хуурай шавардлага нь унасан, салхивчийн нэгдсэн системгүй байна.

Б. Шинжилгээний байр:

Тухайн барилга нь тэнхлэгээрээ 15.0x14.0 метрийн хэмжээтэй, угсармал бетон суурь, тоосгон ханатай, хавтгай дээвэртэй, нэг давхар, 1986 онд ашиглалтад орсон, ашиглалтад орсоноос хойш их засвар хийгдэж байгаагүй, хур тундасны ус барилгын дээврийг нэвтрэн халтартуулсан, хөгц мөөгөнцөр үүссэн, хуурай шавардлага нь унасан, модон цонх, хаалга нь хэв, гажилтад орсон зэрэг дээрх зөрчил дутагдал нь "Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм "БНБД 13-04-03-ын 1, 2,3, 3.1-д заасан / ...Хар цаасан дээврийн эдэлгээний нормт хугацаа 10-15 жил..... инженерийн шугам сүлжээний засвар ашиглалтын хугацаа 15-25 жил.../ хугацаанд нэгдсэн их засвар хийхгүйгээр ашигласнаас болсон байна.

В. Био үйлдвэрлэлийн лабораторийн барилга:

1. Дээврийн засвар хийхээс өмнө нь хур тундасны ус их хэмжээгээр гоожиж байсан, агааржуулалтын систем төлөвлөгдөөгүй, үйл ажиллагаанаас хамаарч их хэмжээний чийг ялгардаг зэргээс ус чийг их хэмжээгээр хуримтлагдсан, хана, таазны замазка эмүльс нь хуурч хөгц мөөгөнцөрт идэгдсэн нь төлөвлөлийн болон ашиглалтын буруугаас;

Г. Лаборатори, өргөтгөл:

Хуучин лаборатори нь төв корпустайгаа 1978 онд ашиглалтад орсон, лабораторийн

өргөтгөл нь "Би Софт констракшн" ХХК-ийн зураг төслөөр "Нью музе" ХХК барилга угсралтын ажлыг нь гүйцэтгэн 2009 онд ашиглалтад оруулсан тэнхлэгээрээ 15.0x16.2 метр хэмжээтэй, хосолмол хийцтэй, хоёр давхар барилга байна.

Энэхүү лабораторийн өргөтгөлийн барилга нь агаарын урсгал гаднаас дотогш чиглэлтэй, эргэж гарахгүйгээр био аюулгүй ажиллагааны 2 дугаар зэрэглэлд хамаарах барилга бөгөөд салхивчийн систем ажилладаггүй, тоног төхөөрмжийн сантехникийн холболтыг салгасан, холболтын систем нь ойлгомжгүй, агаар өгөх системийг ажиллуулахгүй удсанаас / бүх цонх нь хаалттай/ өрөө тасалгаанууд нь бүгчим, эвгүй үнэртэй, хүн удаан хугацаагаар ажиллах боломжгүй, өрөөнөөс агаар хаяж байгаа хэсэгт шүүлтүүр байрлуулаагүй, хуучин лабораторийн барилгын агаар сэлгэлтийн хоолой нь зарим газраараа тасарсан, хөдөлгүүр нь ажилладаггүй орчинд үйл ажиллагаа явуулж байгаа нь: "Барилгын тухай" хуулийн 9.1.1 "Барилга байгууламж нь хүн ажиллаж, амьдрах таатай нөхцөл бүрдүүлсэн, түүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, аюулгүй байдлыг хангасан байх" заалтын шаардлагыг хангахгүй байна

Дээрх байдлаас үндэслэн ДҮГНЭХ НЬ:

1.Төв корпусын барилгын цэвэр ус, халаалтын шугамыг засварлах, сувгийг бүрэн нээж сувгийн тоосгон ханыг шинээр өрөх, нойтон хөрсийг хатаах, хөрс солилт хийх, өрөө тусгаарлах ханыг буулган шинээр өрөх, хагаралт, суулт өгсөн хана, хэсэгт маяк тавьж ажиглалт хийх, шаардлагатай гэж үзвэл барилгын бат бөхийг итгэмжлэгдсэн лабораториор тодорхойлуулах, шинжилгээний байрны дээврийн болон бусад засварыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар зураг төсөл хийлгэн нэгдсэн их засвар хийх шаардлагатай.

2. Тус лаборатори нь био аюулгүй ажиллагааны 4 дүгээр зэрэглэлийн 2 дугаар түвшинд үйл ажиллагаа явуулдаг ч эрсдэл нь 3 дугаар зэрэглэлийн ч шаардлага хангахгүй байгаа тул дээрх барилгуудын агааржуулалтын системийг мэргэжлийн байгууллагын тооцоо судалгааны үндсэн дээр зураг төслийг хийлгэж биологийн аюулгүй ажиллагааны зэрэглэлийн шаардлага хангасан тохиолдолд ашиглах боломжтой.

БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ



Ж.ЦЭЭЛЭЭ